

ПОЛИТОЛОГИ VI
Эрдэм шинжилгээний бичиг

УЛС ТӨРИЙН ФИЛОСОФИЙН СУДЛАХ ЗҮЙЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Ч.Баатар багш, докторант

Удирдлагын Академи, Нийгмийн удирдлагын тэнхим

Өгүүллийн зорилго: Улс төрийн философи нь тогтсон ойлголтуудын хэлхээс бүхий философийн нэг салбар боловч нийгмийн улс төрийн амьдралын өөрчлөлтөөс үүдэн түүний үндсэн ойлголт, судлагдахууны хүрээ байнга өөрчлөгдөж байдаг. Иймд энэхүү бэсрэг өгүүлэгийнхээ хүрээнд тэдгээр өөрчлөлтийн зарим тал хандлагыг илэрхийлэхийн сацуу уламжлалт ойлголтуудыг ч дурьдан харьцуулах үүднээс түүний судлах зүйл, хамрах хүрээнд гарч буй өөрчлөлтийг илэрхийлэхийг зорьсон болно.

Түлхүүр үгс: Улс төрийн философи, улс төрийн сэтгэлгээ, нийгмийн бүтэц, зохион байгуулалт, төрийн байгууламж, улс төрийн философийн судлах зүйл

Мэдлэгийн бие даасан салбар тус бүр нь өөрийн судлагдахуунтай, голлон авч үздэг асуудлын хамрах хүрээтэй байдаг. Тэгвэл улс төрийн философи бие даасан салбар ухааны хувьд юуг судалдаг вэ? түүний онцлог, байр суурь нь ямар байна вэ? ямар хүрээг хамрах вэ? гэсэн асуулт зүй ёсоор урган гарна.

Философичдын үздэгээр улс төрийн философи хэдийгээр 2500-аад жилийн түүхтэй боловч бүр хожим буюу XIX зууны сүүлч, XX зууны эхээр л философийн бие даасан салбар болж зохион байгуулагдан албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн гэж үздэг.

Улс төрийн философийн үндсэн асуудлыг түүний судлах зүйл гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл улс төрийн философид хамааралтай зүйлс, философийн улс төрд хамааралтай зүйлс нь үүнд хамаарна хэмээн өргөн утгаар нь ойлгож болно. Гэвч энэ нь нөгөө талаас хэт ерөнхий, өрөөсгөл ойлголт болох нь мэдээж юм. Орчин үед улс төрд хамааралтай философийн асуудлыг улс төрийн философи буюу улс төржсөн философи гэж нэрлэж байна.

¹Энэ ойлголт ч учир дутагдалтай бөгөөд орчин үед улс төрд шууд хамааралтай, бүр уламжлалын дагуу улс төрийн философийн үндсэн асуудлын хүрээнд заавал яригддаг зарим нэг асуудал нь улс төрийн бодит амьдрал дээр философийн асуудал биш болж энгийн ойлголтын хүрээнд тайлбарлагдах боломжтой болдог. Жишээ нь төрийн тухай асуудал бол улс төрийн философийн үндсэн асуудлын нэг мөн. Гэтэл орчин үед бодит амьдрал дээр төрийн асуудлыг маш хялбархан, бүр Засгийн Газар (төрийг явцуу утгаар нь Засгийн Газар гэж үздэг) гэсэн ойлголтынх нь үүднээс улс төрийн намын тухай үзэл баримтлалаар тайлбарлаж болно. Энэ нь сүүлийн үеийн улс төрийн

¹ [Shadia B. Drury](#), "The Roots of Postmodern Politics" New York, 1995

судлагааны бүтээл, нэг сэдэвт зохиолуудад улс төрийн нам бол төрийн бус байгууллага, өөрөөр хэлбэл иргэний нийгмийн биежсэн хамгийн том төлөөлөл юм гэсэн ойлголт газар авч сурталчлагдах болсонтой холбоотой. Үүнд төр бол угтаа засгийн эрхэнд гарсан улс төрийн нам бөгөөд намын уг сурвалж нь иргэдийн улс төрийн сонирхол, хүсэл эрмэлзэлийн илэрхийлэл байдаг. Тэгэхлээр улс төрийн нам нь төрийн бус байгууллагын шинжийг бүрэн илэрхийлж байдаг гэсэн үг юм. Үүнтэй холбоотойгоор улс төрийн философийн тухай үндсэн ойлголт, судлах зүйлийн хүрээнд ихээхэн өөрчлөлт гарч байна. Орчин үеийн улс төрийн философийн судлах зүйлийг сүүлийн үеийн судалгааны зохиол бүтээл, нэр нөлөө бүхий сурах бичгүүдэд дурьдсаныг иш болговол дараах байдлаар томъёолж болно. Үүнд:

- Улс төрийн сэтгэлгээний хөгжлийн асуудал
- Философи дахь улс төрд хамааралтай, улс төрийн амьдрал дахь философид хамааралтай буюу харилцан бие биендээ шилждэг асуудлууд зэрэг юм.

Нөгөө талаас улс төрийн философи гэсэн нэр томъёо нь өөрөө энэхүү салбар ухааны үндсэн агуулга, мөн чанарыг ойлгох зах сэжүүр болдог. Энэ талаар философич Л.Штраус (1899-1973) өөрийн нэгэн бүтээлдээ улс төрийн философи гэсэн нэрийг бүрдүүлж буй улс төр хийгээд философи гэсэн хоёр үгийн нийлбэр утгыг тайлбарлахдаа: "... улс төрийн гэсэн тодотгол бүхий тэмдэг нэр нь улс төрийн философийн судлах зүйл ба гүйцэтгэх үүргийг илэрхийлж байна, өөрөөр хэлбэл улс төрийн философи нь улс төрийн амьдрал, улс төрийн үйл хэрэгт хандаж авч үздэг болохыг харуулан зааж байна, харин "философи" гэсэн үг нь улс төрийн амьдралыг оюун санааны хөгжлийн хүрээнд авч үзэх аргыг зааж байгаа юм. Тэгэхлээр улс төрийн философийн авч үздэг сэдэв бол хүн төрөлхтний агуу их зорилго, эрхэмлэл болох эрх чөлөө ба засаглал, эсвэл төрийн зохистой байгууламж юм. Улс төрийн философи бол улс төрийн амьдралд хамгийн ойр байдаг философийн салаа мөчир мөн²" гэж бичжээ.

Улс төрийн философийн тухай үзэл санаа олон зуун жилийн турш элдэв төрлийн худал хуурмаг үзэл баримтлал, зохиомол сургаал, атгаг санааны элдэв төөрөгдлөөр хучигдан бүдгэрч, судлах зүйл, шийдвэрлэх асуудал нь янз бүрийн ягшмал номлолын хүлээсэнд баригдан өөрийн мөн чанар, анхныхаа утгыг бүрэн алдахад хүрчээ³. Тэгэхлээр улс төрийн философийг энэ бүх төөрөгдөл ба зарим хүмүүс санаанаас зохиогоод шийдвэрлэвэл зохих асуудал мэтээр удаан хугацаанд дөвийлгөн хэлэлцэж ирсэн асуулт зэргээс цэвэрлэхийн тулд феноменологийг буюу юмс тэргүүтний өөрийгөө нээн харуулах гоц чанарын судалгааг хэрэглэх зорилт сэтгэгчдийн өмнө зайлшгүй тавигдах болсон юм. Үүнээс шууд уламжлан улс төрийн философийн судлах зүйл шинээр томъёологджээ.

² Штраус Л, "Введение в политическую философию" М., 2000

³ Павлов А,В, "Прагматичные наследники политической философии Лео Штрауса" М., 2003

Улс төрийн үйл явцыг нийгмийн хөгжлийн түгээмэл зүй тогтолтой уялдуулан ойлгох, түүнчлэн хүний оюун санааны ертөнцийн өөрчлөлттэй холбож үзэх нь уг салбар ухааны судалгааны шинэ хандлага болоод байна гэж хэлж болно. Энэ үүднээс улс төрийн философийн судалгааны гол субъект тухайн нийгмийг бүрэлдүүлж байгаа хүн хийгээд түүний оюун санааны хэлбэршилт юм. Хүний оюун санааны хэлбэршилтийн бодит тусгал нь нийгэм өөрөө болох бөгөөд энэ нь түүний бүтцийн байдалд хамгийн их тусдаг. Энэхүү бүтцийн байдлын илэрхийлэл нь нийгмийн улс төрийн хүрээ байдаг. Нийгмийн улс төрийн хүрээ нь нийгмийн түүхэн хөгжлийн цаг үе бүхэнд өөр өөр хэв маягаар хөгжиж ирсэн. Энэхүү өөр өөр хэв маягыг бүрэлдүүлэгч нь тухайн улс төрийн хүрээг ойлгох ойлгоц буюу улс төрийн сэтгэлгээ гэж хэлж болно. Нөгөө талаас хүн өөрт бий болсон ойлголтынхоо хүрээнд нийгмийн бүтэц буюу амьдралдаа шаардлагатай орчинг бүрдүүлдэг байна. Хэдийгээр нийгмийн улс төрийн хүрээ тухайн нийгэмд амьдарч байгаа хүний хүсэл эрмэлзэл мэт харагдавч угтаа уг хүрээг ойлгох түгээмэл үзэл баримтлалтай холбоотой байдаг. Энэхүү түгээмэл үзэл баримтлал нь нэг талаас ертөнцийг үзэх үзлийн хэв шинжийг өөртөө бүрэн агуулж нөгөө талаас номлол сургаал маягаар нийгмийн харилцааг зохицуулах гол хэрэгсэл болж оршдог.

Нийгмийн нэг мөн чанар нь орчин тойрон, цаг үеийнхээ үзэл санаа, хандлагыг давтагч, түүний биелэл болсон хүмүүсийн нэгдэл байдаг. Үүгээрээ нийгэм нь даган дууриалалт, ижилсэлтийн цогц орчин болдог. Энэхүү орчин дахь үзэгдлүүдийн хамгийн түгээмэл хэлбэршилт түүний бүтэц, зохион байгуулалт болно. Түүний нийгэм дээр хамгийн түгээмэл хэлбэр нь улс төр бөгөөд бодит хэрэгжүүлэлт нь төр юм. Төрийн үндсэн шинж заавал нэг сэтгэлгээний илэрхийлэл буюу тодорхой нэг үзэл баримтлалаар дамжин илэрхийлэгддэг бөгөөд орчин үед үүний түгээмэл хэв маяг ардчилал болоод байна. Энэ үүднээс ардчиллыг улс төрийн сэтгэлгээний нэг үндсэн хэлбэр гэж үзэх бүрэн үндэслэлтэй бөгөөд нөгөө талаас ертөнцийг үзэх үзэл ч гэж болох талтай. Гэхдээ орчин үеийн улс төрийн философийн сүүлийн үеийн судлагаануудад ардчиллыг ихэвчлэн улс төрийн сэтгэлгээ⁴ гэдэг үүднээс тайлбарлаж байна. Үүний учир нь нэгэнт сэтгэлгээний аливаа хэлбэр нь тухайн нийгэмд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд тодорхой үзэл баримтлалын агуулгыг илэрхийлж эхэлдэг гэсэн ойлголтыг нийтээр баримтлах болсонтой холбоотой⁵ юм. Хэдийгээр уламжлалт судлагааны хүрээнд ардчиллыг үзэл суртал хэмээн үздэггүй ч сүүлийн үеийн судалгааны зохиолуудад тэрээр ардчилал нь сэтгэлгээ болохын сацуу дэлхий нийтэд аль хэдийн хүлээн зөвшөөрөгдсөн учраас ертөнцийг үзэх үзлийн нэг хэлбэр гэж үзэж болно гэжээ⁶.

Аливаа сэтгэлгээ тодорхой цаг үеийн нийгмийн хөгжлийн түвшин, сэтгэлгээний хэв маяг, оюун ухааны төлөвшилттэй шууд холбоотой байдаг. Улс

⁴ McCarthy “Musings on Postmodern Politics”, [National Humanities Institute](#) Washington, DC., 2007

⁵ Cooper B. Eric “Voegelin and the Foundations of Modern Political Science”, Columbia–L., 1999

⁶ Eugene McCarthy “Musings on Postmodern Politics”, [National Humanities Institute](#) Washington, DC., 2007

төрийн сэтгэлгээ ч гэсэн нийгэм дэх хүний оюун ухааны ухамсартай үйл ажиллагаа бөгөөд тухайн нийгмийнхээ улс төрийн орчин, үйл явцтай холбоотой бий болсон оюун санааны хийсвэрлэл нь бодит байдал руу шилжих үйл ажиллагаа гэж үзэж болох талтай.

Улс төрийн сэтгэлгээ нь тодорхой ухамсарыг өөртөө төлөвшүүлсэн бие хүмүүс бүхий нийгэм, тодруулбал ард түмэн, үндэстэн ястан, байдаг. Нөгөө талаас улс төрийн аливаа сонирхлыг илэрхийлэгч бие хүн, эсвэл тодорхой хүн амын бүлэг байдаг. Энэхүү субъект нь нийгэмд явагдаж буй улс төрийн үйл явц, үзэгдлийг өөрсдийн оюун ухааныхаа хүрээнд ажиглан харж, мөн чанарыг нь тусган ухаарч түүнийг тодорхой загварт оруулан илэрхийлж байдаг бөгөөд энэ үйл ажиллагаа нь улс төрийн сэтгэлгээгээр илэрхийлэгддэг.

Улс төрийн сэтгэлгээ нь хүний сэтгэлгээний дөрвөн үндсэн шинжийг бүгдийг нь өөртөө тусган илэрхийлж, тэдгээртэй нягт харилцан уялдаж байдаг. Учир нь улс төрийн сэтгэлгээний хэлбэрүүд нь хүн төрөлхтний түүхэн хөгжлийн бүхий цаг үед нийгэм дээрх бүтэц, зохион байгуулалтыг бүрэлдүүлэгч нь болсоор иржээ. Улс төрийн сэтгэлгээ дараах өвөрмөц онцлогыг агуулна. Үүнд:

- Улс төрийн сэтгэлгээний нийгмийн амьдралыг тодорхой зохион байгуулалт, бүтцэд оруулдагаараа ихэвчлэн бүтэцлэгдсэн, тогтолцоот хэлбэртэй байдаг.
- Улс төрийн сэтгэлгээ нь нийгмийн тодорхой бүтэц зохион байгуулалтыг илэрхийлдэг учраас түүхэн цаг үеийн шинжтэй байдаг.
- Улс төрийн сэтгэлгээ нь эцэстээ бодитой үйл ажиллагаа болон хувирах эрмэлзэлтэй байдаг учраас гол төлөв номлол, үзэл баримтлалын шинжтэй болдог.
- Улс төрийн сэтгэлгээнд гол төлөв засаглалын шинж ямар нэг байдлаар агуулагдаж байдаг учраас нийгэм дэх төрийн удирдлагын үндэс болдог.

Энд улс төрийн сэтгэлгээг тодорхой логик загварт оруулж түүний судлагдахуйн хүрээг авч үзвэл тэр нь бие даасан философийн салбарыг бий болгох нь дамжиггүй. Энэхүү бие даасан философийн салбар нь улс төрийн философи гэж болно.

Улс төрийн философи ялангуяа улс төрийн шинжлэх ухаантай нягт уялдаатай байх ойлгомжтой. Энэ нь тэдгээрийн авч үздэг асуудал ихэнх тохиолдолд давхарддагтай нэн түрүүнд холбоотой. Тухайлбал төр, улс төрийн засаглал, улс төрийн бодлого зэрэг улс төрийн амьдралын гол гол үзэгдлийг энэ хоёр салбар ухаан аль аль нь авч үздэг. Улс төрийн философи бол улс төрийн амьдралыг судалдаг янз бүрийн шинжлэх ухаанаас ялгарах олон онцлогтой. Эдгээр нь тус бүрдээ онцлог бүхий судлах зүйлийг бий болгодог. Үүнд:

Нэг. Улс төрийн амьдралын баримтат, эмпирик үзэгдлийг улс төрийн шинжлэх ухаан илүүтэй онцолдог бол мөн чанарлаг, ерөнхий, давтагдагч утга, зүйл тогтлыг улс төрийн философи нь илүүтэй онцолдог байна. Ийм учраас улс төрийн шинжлэх ухаанд “хэзээ”, “хаана”, “яаж”, “хэн”, “юу”, “хэний”, “юуны”, “яасан”, “ямар байх ёстой” гэх асуултад хариулах нь гол байдаг бол улс төрийн философид “...гэж юу вэ?” хэмээх Сократын асуулт гол нь байдаг.

Хоёр. Улс төрийн шинжлэх ухаан нь ажиглалт, туршилтын үр дүнг болон баримт, үйл явдлыг бодитой илэрхийлж чадаж буй нөхцөлдөө агуулгын хувьд нэлээд объектив байж чаддаг бол улс төрийн философи үлэмж тохиолдолд априори үндэслэлүүдэд тулгуурладаг тул түүний янз бүрийн чиглэлд субъективизм багагүй нөлөөлсөн байна.

Улс төрийн философи, улс төрийн шинжлэх ухааны үндсэн ойлголтуудын шилжилтийг түүхийн философи ба түүхийн шинжлэх ухааны салбарууд, эдийн засгийн философи ба эдийн засгийн шинжлэх ухааны салбарууд, эрх зүйн философи ба эрх зүйн шинжлэх ухааны салбарууд, соёлын философи ба соёл судлалын шинжлэх ухааны салбарууд, гоо зүй ба урлагийн онолууд, ёс зүй ба ёс зүйн хавсарга ойлголтууд зэрэгт ч хэрэглэдэг бөгөөд энэ философийн асуудал, шинжлэх ухааны асуудал хоёрын зааг ялгааг тогтоох нэг чухал арга зүйн үндэс болж өгдөг.

Улс төрийн философийг сонгодог онол, орчин үеийн онол гэж хоёр хувааж болно. Ерөнхий шинжээр авч үзвэл сонгодог улс төрийн философийн онолуудыг нийгмийн зохистой бүтэц, зохион байгуулалтыг хэрхэн бий болгох тухай арга зүйн зөвлөмж өгдөг онолууд гэж тодорхойлж болно⁷. Харин орчин үеийн улс төрийн философийн онолууд нь юуны өмнө нийгэм дэх улс төрийн амьдралын ээдрээтэй асуудлуудад философийн задлан шинжилгээ хийх, өөрөөр хэлбэл улс төрийн тулгамдсан асуудалд хэрхэн хандах талаар зохистой утгыг сэтгэлгээний үүднээс олж, тодруулахад анхаарлаа төвлөрүүлдэг.

Улс төрийн философи ерөнхий философийн бие даасан нэгэн том салбар болохын хувьд хүний мэдлэг, танин мэдэхүй хийгээд хүмүүжил, нийгэмшил, түүнчлэн нийгмийн амьдрал, соёлд олон талтай чухал үүргүүдийг гүйцэтгэдэг. Тэдгээрийг ертөнцийг үзэхүйн, онол-танин мэдэхүйн, арга зүйн, шүүмжлэх, гэгээрүүлэн хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, үнэлэмжийн, хэм хэмжээ тогтоох, таамаглах гэсэн бүлэгт ангилж болно. Эдгээр ангилал бүхий үүргийн агуулгыг товч дурдвал улс төрийн философи нь дараах байдлаар төсөөлөгдөж болно. Үүнд:

- Нийгмийн орчин, нийгмийн бүтэц, зохион байгуулалт, түүний хөгжил, өөрчлөлт, илэрч буй түгээмэл үзэгдлүүдийг ертөнцийг үзэх түгээмэл үзлийн үүднээс ойлгох, судалж, танин мэдэх үүргийг гүйцэтгэнэ.

⁷ Аврум Стролл, Ричард Поупкин, “Гүн ухаан” УБ., 1998

- Улс төрийн үзэгдэл үйл явц, түүнийг судлахад шаардагдах ойлголт, ухагдахууны хамрах хүрээ, ерөнхий хийгээд үндсэн зарчим, хандлагуудыг боловсруулдаг байна
- Улс төрийн олон талт амьдралыг судлах судалгааны ерөнхий логик, зорилго, зорилт, бүтцийг зөв зүйтэй зохион байгуулах чиглэл, заалт өгдөгөөрөө арга зүйн үүрэгтэй.
- Улс төрийн бодит байдлыг шүүмжлэлтэй, нийгмийн хөгжлийн тухайн цаг үеийн хэм хэмжээнд тулгуурлан авч үзэж үнэлэлт өгөн, байвал зохих зүйлийг илэрхийлдэгээрээ шүүмжлэх, үнэлэх, хэм хэмжээ тогтоох үүрэгтэй.
- Хүмүүст улс төрийн философи нь мэдлэг, боловсрол олгож улс төрийн ухамсар, соёл төлөвшүүлдэг бөгөөд бие хүнийг нийгэмшүүлэх үүргийг ч зарим үед өөртөө агуулдаг байна.

Мөн улс төрийн философийн үндсэн ойлголтуудын нэг болох төрийн засаглал нь бусад хүнийг засаглахдаа ямар заагаар хязгаарлалт бий болгох, иргэдийн улс төрийн эрх чөлөөг хязгаарлахгүйгээр тэдний хүсэл, эрмэлзэлд үндэслэсэн үйл ажиллагааг хянах боломж байна уу? хууль тогтоох засаглалын сонгуульт төлөөлөгчид зөвхөн өөрт зохистой санагдсан саналыг оруулах ёстой юу? эсвэл зөвхөн сонгогчдынхоо олонхийн улс төрийн сонирхлыг илэрхийлж байх ёстой юу? гэх мэт асуудлыг судалдаг.

XX зууны 30-аад он хүртэл улс төрийн философийн онол, арга зүй, танин мэдэхүйн асуудлуудыг судалж боловсруулахад Ж.Локк, Ш.Л.Монтескье, Г.Гегель, И.Кант, К.Маркс, А.Смит, В.Парето, М.Вебер, А.Мишель, Л.Дюги, Б.Кроче, К.Шмитт болон бусад эрдэмтэд багагүй хувь нэмэр оруулжээ. Гэвч XX зууны 1930-аад оноос 1950-иад он хүртэлх үед улс төрийн философийн судалгаа зогсонги байдалд орж тодорхой ахиц, ололт гараагүй гэж үздэг.

Харин 1950-иад оноос эхэлж Х.Арендт, Л.Штраус, Э.Вогельн, М.Фуко, Ж.Роулз, Р.Нозик, Г.Рормозер, И.Кальтенбрунер зэрэг сэтгэгчдийн судалгаа, сонирхолтой зохиол бүтээлийн үр дүнд улс төрийн философи дахин сэргэжээ. Ялангуяа 1971 онд АНУ-ын философич Ж.Роулзын "Шударга ёсны онол" 1971 онд, дараа нь Р.Нозикийн "Анархи ёс, төр ба утопи үзэл" 1974 онд хэвлэгдэн гарч эрдэмтэн судлаачдын анхаарлыг ихэд татсан бөгөөд улс төрийн философийн судалгааг шинэ шатанд гарахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

АНУ-ын философич Ж.Роулз нийгмийн улс төрийн зохион байгуулалтын чухал зарчим, нийгмийн үнэт зүйл болох шударга ёсны асуудлыг өргөн хүрээ, агуулгаар судлажээ. Тэрээр "үнэн нь шинжлэх ухааны хувьд эцсийн үр дүн байдгийн нэгэн адил шударга ёс нь төр, түүнийг төлөөлөн үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын (институт) хувьд хамгийн чухал зүйл болно. Төр хичнээн ч үр ашигтай ажилласан ч гэсэн нийгэмд шударга бус байдал бий болсон тохиолдолд түүнийг заавал өөрчлөх хэрэгтэй болно" гэсэн санааг өөрийн "Шударга ёсны онол" хэмээх зохиолдоо гаргасан байдаг.

Роулзын энэхүү суурь бүтээлийн гол үзэл санааг Нозик шүүмжлэхийн хамт: "Роулзын шударга ёсны онол бол улс төрийн болон ёс зүйн философийн чиглэлийн хүчтэй, гүн гүнзгий, түгээмэл өргөн агуулга бүхий тогтолцоотой бүтээл бөгөөд хэрэв харьцуулж болдогсон бол Жон Стюарт Миллээс хойш түүнтэй дүйцэх зохиол гараагүй билээ" гэж бичиж байв. Тэрээр улс төрийн философчид одоо нэг бол Роулзын онолын хүрээнд ажиллах, эс тэгвээс яагаад үгүй гэдгээ тайлбарлах хэрэгтэй боллоо⁸" гэж өндөр үнэлсэн байна. Харин Р.Нозик бүтээлдээ нийгмийн улс төрийн зохион байгуулалтад төр бага оролцох тухай либерализмын асуудлыг орчин үеийн амьдралтай холбож шинэлэг байдлаар авч үзжээ.

АНУ-ын Харвардын Их сургуулийн философийн профессор Роберт Нозик: "Хэрэв төр байгаагүй бол түүнийг бий болгох шаардлагатай юу? Төр ер нь хэрэгтэй юу? Түүний хэрэгцээ, шаардлага байна уу? Улс төрийн философиос үүдэлтэй эдгээр асуулт улс төр гэдэг үзэгдэлийг тайлбарлахад тус дөхөмтөй. Улс төрийн философийн үндсэн асуудал бол төрийг хэрхэн зохион байгуулахаасаа илүү, төр ер нь байх ёстой юу гэсэн санаа байдаг⁹" гэж бичжээ.

Судлаачдын ихэнх нь улс төрийн философи Роулз, Нозик нарын дараа дахин уналтад орсон, одоогоор ухаан бодол баясгаж, анхаарал татахуйц ямар нэг шинэ онол, урсгал чиглэл, эсвэл нийтээр зөвшөөрсөн нэгдмэл үзэл баримтлал гарахгүй байна, улс төрийн философи одоогоор нийгэм, улс төрийн амьдралын нарийн эдрээтэй асуудлуудад анхаарал хандуулахаасаа илүү өөрийн онол, арга зүйн асуудлын хүрээн дотор эргэлдэж, их сургуулиудын мэргэжлийн анги салбаруудад хичээл болон судлагдах нь давамгайлж байгаа талаар багагүй бичсэн байдаг¹⁰. Гэвч одоогоор улс төрийн философийн судлагдахуун, үндсэн асуудал, онол, арга зүй, философи болон улс төрийн шинжлэх ухааны тогтолцоонд түүний эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийн талаар бодож сэтгэх, судалгаа хийх хэрэгцээ шаардлага чухал хэвээр байгаа юм.

Улс төрийн философичдын энэ талаарх үзэл бодлын авч үзвэл Л.Штраус: "Улс төрийн философи нь нэг талаар улс төрийн юмс үзэгдлүүдийн жинхэнэ мөн чанар, уг шинжийг тодруулж тогтоохыг хичээдэг бол нөгөөтэйгүүр зүй зохистой, эсвэл шилдэг сайн улс төрийн дэглэм гэж юу вэ, ер нь ямар байх вэ? гэдгийг мэдэж ойлгохыг оролддог¹¹" гэж бичжээ.

Тухайн асуудлыг бодит амьдралтай холбож үзвэл хүмүүст хамгийн амин чухал, юуны өмнө ухаарч мэдвэл зохих, өдөр тутмын үйл ажиллагаандаа заавал мөрдөж байвал зохих улс төрийн мэдлэг юу вэ? гэсэн асуулт болон хувирдаг.

⁸ Роберт Нозик, "Анархи ёс, төр, утопи үзэл" УБ., 2006

⁹ Энэ талаар Оросын эрдэмтэдийн ялангуяа Гаджиев К.С. Политическая философия. М., 1999, Панарин А.С. "Философия политики" М., 1996. зохиолуудад тодорхой үндэслэлтэйгээр тусгагдсан байна.

¹⁰ Мөн тэнд

¹¹ Штраус Л. "Введение в политическую философию" М., 2000

Энэ цаашдаа хүний амьдралд шийдвэрлэх үүрэгтэй, хүмүүст байнга, хамгийн их нөлөөлдөг улс төрийн хүчин зүйл юу вэ? гэсэн асуултад тулж очдог. Үүнийг судалж үзвэл хүмүүст хамгийн хүчтэй, гүн гүнзгий байнга нөлөөлдөг тийм улс төрийн хүчин зүйл нь хүн өөрөө байдаг. Эндээс хүнд хүнээс илүү, байнга нөлөөлдөг өөр улс төрийн хүчин зүйл байхгүй гэсэн дүгнэлтэд хүрнэ. Тэгэхлээр нийгмийн орчинд хүн хүнээ ойлгох, хоорондоо зохицох, бат бэх найдвартай холбоог тогтоох асуудал юунаас ч илүү чухал анхдагч, суурь шинжтэй асуудал болдог. Энэ нь улс төрийн философийн үндсэн асуудал болдог.

Английн философич Жоннатон Вольф: "Хувь хүний бие даасан байдал хийгээд засаг захиргаа хоёрын тэнцвэрт харилцаа, өөрөөр хэлбэл улс төрийн эрх мэдлийн зохист харилцааг тогтоох явдал нь улс төрийн философийн онцлог шинж буюу хэм хэмжээ (дүрэм журам буюу оюун санааны стандарт) тогтоох норматив шинжийг харуулж байна. Улс төр судлаач, социологич, түүхчид улс төрийн дескриптив судалгаа хийдэг¹² гэжээ. Жишээ нь, улс төр судлаачид АНУ-д хэн үнэт зүйлсийг хуваарилж, үндэсний баялгийг эзэмшиж байна, Хятадад хэн засгийн эрхийг барьж байна гэх мэтчилэн, "хэн", "хэрхэн" гэсэн асуудлыг сонирхдог байна. Тэгвэл улс төрийн философичид нь эдгээр асуудлыг сонирхох нь мэдээж боловч гол анхаарал маань эд баялаг болон үнэт зүйлсийг хуваарилахад ямар зарчим дүрмийг баримтлах ёстой вэ? ("эд баялаг, үнэт зүйл" гэдэгт зөвхөн материаллаг баялаг биш эрх мэдэл, эрх чөлөөний асуудал ч бас хамаатай) гэсэн асуудалд анхаарлаа хандуулна. Мөн улс төрийн философи нь "баялгийг хэрхэн хуваарилах вэ?", "хүмүүс ямар эрх, эрх чөлөөтэй байна вэ?" гэх биш "баялгийг хуваарилах зарчим баримтлавал илүү шударга, зүй ёсны, зохистой болох вэ?", "хүмүүсийн нийгэм дээрх ямар үйл байдлыг эрх, эрх чөлөө гэх вэ? гэж асуудаг¹³" хэмээн бичжээ.

Интернет дэх "Википедиа" хэмээх нэвтэрхий толь хийгээд нэгтгэн дүгнэж бичсэн бусад судлагааны зохиолуудаас үзвэл орчин үеийн улс төрийн философийн судлах зүйл нь хувь хүн ба нийгмийн хоорондын харилцаа ямар байвал зохистой вэ? гэсэн асуултаас судалгаагаа эхэлдэг бөгөөд авч үздэг гол асуудал нь нийгэм дэх хүмүүсийн хамтын амьдралыг хэрхэн яаж зүй зохистой, сайн сайхан болгож зохион байгуулах вэ? үүний тулд нийгмийн баялаг, үнэт зүйлсийг яаж шударга хуваарилах вэ? иргэдийн эрх, эрх чөлөө, дэг журам, хариуцлага, тэгш эрх, шударга ёсыг яаж хэрэгжүүлэх вэ? үүнд төр засаг, хууль зүй ямар үүрэг оролцоотой байвал зохих вэ? гэсэн асуултууд юм гэсэн нийтлэг утга агуулгатай үзэл санаа томъёологдсон байна.

Дээр дурдсаныг иш үндэс болгож улс төрийн философийн голлон судалдаг үндсэн асуудал эдүгээ тодорхой болж тогтоогүй байгаа боловч нийгмийн бүтэц, зохион байгуулалт, түүний түгээмэл¹⁴ зарчмын тухай асуудал мөн хэмээн ерөнхий ухагдахууны хүрээнд тодорхойлж болно. Эндээс харахад

¹² Вольф Ж. Улс төрийн философийн удиртгал. УБ., 2002

¹³ Вольф Ж. Улс төрийн философийн удиртгал. УБ., 2002

¹⁴ Универсал

улс төрийн философийн судлах асуудлын хүрээ багтаамж өргөн, дотроо нарийн нийлмэл бүтэцтэй, бүрдэл хэсгүүд нь нэг нь нөгөөгөөсөө урган гарч шатлан эрэмбэлсэн түвшинтэй байна.

Мөн одоогоор бий болоод байгаа улс төрийн философийн онолын мэдлэгийн тогтолцоог нийгмийн улс төрийн ахуй хийгээд эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны тухай сургаал, улс төрийн танин мэдэхүйн онол, арга зүй, улс төрийн аксиологи, улс төрийн философийн түүх зэрэг нь бүрдүүлж байна. Тэдгээр нь тус бүртээүндсэн асуудал, судалгааны тогтсон хамрах хүрээтэй. Гэхдээ эдгээрийг нэгтгэн зангидаж гүнзгий үндэс суурь нь болдог ойлголт нь нийгмийн бүтэц, зохион байгуулалт буюу улс төр юм. Тиймээс улс төрийн философи түүнийг нэн түрүүнд чухалчлан авч үзэж мөн чанар, үндсэн утга агуулга, гол зорилго, зорилтыг нь судлахыг хичээж байна.

Философичдын зарим нь үүнийг иш үндэс болгож улс төрийн философийн авч үздэг гол зүйл бол төр мөн гэж үздэг тал бий. Гэвч энэ улс төрийн философийн судлах зүйлийн зөвхөн нэг хэсэг нь болох бөгөөд түүнийг нийгмийн сэтгэлгээний өөрчлөлттэй холбож судлах хэрэгтэй болно. Мөн дээр өгүүлсэнчлэн төр бодит хандлага талаасаа улс төрийн философийн ухагдахуун бүр биш ч байж магадгүй болно. Иймд сүүлийн үед уг асуудлыг хөндөн судлаж буй философичдын зохиол, бүтээлээс үзэхэд улс төрийн философи нь нийгмийн бүтэц, зохион байгуулалтын мөн чанарын тухай салбар ухаан юм гэж дүгнэлт хийхэд хүрсэн нь санамсаргүй зүйл биш юм.

Улс төрийн шинжлэх ухааны судлагдахуун нь улс төрийн хүрээгээр хязгаарлагддаг бол улс төрийн философи түүгээр хязгаарлагдахгүй, харин түүнээс халин гарч улс төрийг нийгмийн амьдралын зохион байгуулалттай холбон өргөн дэвсгэр суурин дээр авч үздэг. Энэ нь улс төрийн философи өөртөө зохиомолоор судлах асуудал бий болгож байгаа хэрэг биш юм. Нийгмийн амьдралын зохион байгуулалт, түүний зарчим, хэм хэмжээ, эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс, нийтийн ашиг тус, сайн сайхан байдал, дэг журам зэрэг үнэт зүйлс, эрхэмлэл нь угаасаа улс төрийн уг чанартай, улс төртэй салшгүй холбоотой бөгөөд улс төрийн философи түүнийг илрүүлэн гаргаж танин мэдэх зайлшгүй шаардлагатай болдог.

Улс төрийн философи асуудалд тийнхүү хандаж шийдвэрлэсэнээр нэг талаас нийгмийн амьдралын зохион байгуулалт, түүний зарчим, хэм хэмжээнүүд нь улс төрийн уг чанар, утга учиртай болох, нөгөөтэйгүүр улс төр нь нийгмийн уг чанар, утга учиртай, өөрөөр хэлбэл нийгэм, хүнд хандсан, тэдгээрийн хэрэгцээгээр оршин байдгийн гүнзгий үндэс шалтгааныг илрүүлэн гаргаж ирнэ. Түүнийг нэг талаас нийгмийн философи, нөгөө талаас улс төрийн шинжлэх ухаан дангаараа бүрэн гүйцэд илрүүлэн гаргаж хараахан чадахгүй. Энэ бэрхшээл тэдгээрийн тус бүрийн зорилго, судлагдахууны хүрээ нь тодорхой заагтай байдагтай холбоотой. Харин улс төрийн философи тэдгээрийн зааг уулзвар дээр, аль алиных нь үндсэн агуулгыг хослуулж судалгаа хийдгийн үр

дүнд судлагдахууныхаа агуулгыг бүрэн гүйцэд, логикийн хувьд үндэслэлтэй болгож чаддаг байна.

Энэ бүхнээс дүгнэж үзвэл улс төрийн философийн судлах зүйл, хамрах хүрээг нийгмийн бүтэц, зохион байгуулалт,¹⁵ түүний мөн чанар, хөгжил, өөрчлөлт юм хэмээх ойлголтоор томъёолж болно.

Ашигласан ном, зохиол:

1. Аврум Стролл, Ричард Поупкин, “Гүн ухаан” УБ., 1998
2. Вольф Ж, “Улс төрийн философийн удиртгал” УБ., 2002
3. Роберт Нозик, “Анархи ёс, төр, утопи үзэл” УБ., 2006
4. Панарин А.С, “Философия политики” М., 1996
5. Павлов А,В, “Прагматичные наследники политической философии Лео Штрауса” М., 2003
6. Штраус Л, “Введение в политическую философию” М., 2000
7. [Shadia B. Drury](#), “The Roots of Postmodern Politics” New York, 1995
8. Eugene McCarthy “Musings on Postmodern Politics”, [National Humanities Institute](#) Washington, DC., 2007
9. Cooper B. Eric “Voegelin and the Foundations of Modern Political Science”, Columbia–L., 1999

Resume: The latest trends in research suggests that the research area and object-matter of political philosophy cover the structure and organization of society as well as its subject matters, development and changes.

¹⁵ Үүнийг Оросын улс төрийн философийн сурах бичгүүдэд политическая организация общества гэж илэрхийлдэг.